

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 05 сарын 09 өдөр
хот

Дугаар 136

Улаанбаатар

Г “Хадгаламж, зээлийн хоршоодын 7
үндэсний холбооноос үзүүлэх тогтворжилтын
үйлчилгээний журам”-ыг батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 54.4, 54.5 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбооноос үзүүлэх тогтворжилтын үйлчилгээний журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллах болон олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН ҮНДЭСНИЙ ХОЛБООНООС ҮЗҮҮЛЭХ ТОГТВОРЖИЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журмын зорилго нь Хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбооноос тогтворжилтын санг байгуулах, сангийн хөрөнгийг бүрдүүлэх, сангийн удирдлага, зохион байгуулалтыг тодорхойлох, сангаас гишүүн хадгаламж, зээлийн хоршоодод тогтворжилтын үйлчилгээ үзүүлэх, сангийн үйл ажиллагаанд хяналт тавих болон холбогдох бусад харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэ журамд хэрэглэгдсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.2.1. “Хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоо” /цаашид “Холбоо” гэх/ гэж Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 49.2-дахь хэсэгт заасан холбоог;

1.2.2. “Хадгаламж, зээлийн хоршоо” /цаашид “ХЗХ” гэх/ гэж Холбооны гишүүн хадгаламж, зээлийн хоршоог;

1.2.3. “тогтворжилтын сан” /цаашид “сан” гэх/ гэж гишүүн ХЗХ-нд тогтворжилтын үйлчилгээ үзүүлэх санг;

1.2.4. “тогтворжилтын үйлчилгээ” гэж Сангаас гишүүн ХЗХ-нд үзүүлж буй удирдлага, санхүүгийн зөвлөх үйлчилгээ, ХЗХ-ны эрсдэлийн түвшин, тогтвортой байдалд мониторинг хийх үйлчилгээ, санхүүгийн хүндрэлтэй болон богино хугацаанд эх үүсвэр нэмэгдүүлэх хүсэлтэй ХЗХ-дод эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг;

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 431 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан/

1.2.5. “заавал байх нөөцийн доод хэмжээ” гэж Холбооны гишүүн бүх ХЗХ-дын нийт хөрөнгийн хэмжээнд үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос /цаашид “Хороо” гэх/ тогтоосон нөөцийн доод хэмжээг;

1.2.6. “тогтворжилтын үйлчилгээний шимтгэл” /цаашид “шимтгэл” гэх/ гэж ХЗХ-доос жил бүр санд төвлөрүүлэх Холбооны тэргүүлэгчдийн зөвлөлөөс тогтоосон шимтгэлийг;

1.2.7. “энэ журамд заасан санхүүгийн хүндрэлтэй хадгаламж, зээлийн хоршоо” гэж Сангаас эрсдэлийн түвшинг үнэлэн төлбөрийн чадваргүй болсон гэж үзсэн ХЗХ-г”.

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 431 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан/

1.2.8. “санхүүгийн туслалцаа” гэж Сангаас Хорооны зөвшөөрлөөр санхүүгийн хүндрэлтэй ХЗХ-нд үйл ажиллагааг нь тогтворжуулах зорилгоор эргэн төлөгдөх нөхцөлтэй үзүүлж буй туслалцааг.

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 431 дүгээр тогтоолоор нэмсэн/

Хоёр. Санг байгуулах, сангийн хөрөнгө, заавал байх нөөцийн доод хэмжээ, сангийн зарцуулалт

2.1. Холбоо нь санг байгуулна.

2.2. Сангийн хөрөнгө нь Холбооны хөрөнгөөс тусгаарлагдсан байх бөгөөд журмын 3.1 дэх хэсэгт заасансангийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зарцуулагдана.

2.3. Сангийн хөрөнгө нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

2.3.1. ХЗХ-доос жил бүр төвлөрүүлэх шимтгэл;

2.3.2. гадаад, дотоодын байгууллага, иргэн, хуулийн этгээдийн хандив, тусламж.

2.4. Сангийн орлого нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

2.4.1. үйл ажиллагааны орлого;

2.4.2. бусад орлого.

2.5. Сангийн заавал байх нөөцийн доод хэмжээ нь Холбооны гишүүн бүх ХЗХ-дын нийт хөрөнгийн 0.01 хувиас доошгүй байна.

2.6. Сангийн мөнгөн хөрөнгийг арилжааны банкин дахь хадгаламжийн дансанд эсвэл тусгайлсан харилцах дансанд байршуулах ба дансны үлдэгдэл нь заавал байх нөөцийн доод хэмжээнээс багагүй байна.

Гурав. Сангийн үйл ажиллагаа

3.1. Сан нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.1.1. санхүүгийн хүндрэлтэй ХЗХ-ны хүсэлтийн дагуу эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн туслалцаа үзүүлэх;

/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 431 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан/

3.1.2. ХЗХ-дын үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийх;

3.1.3. ХЗХ-г эрсдэлээс сэргийлэх, санхүү, удирдлагын заавар, зөвлөгөө өгөх;

3.1.4. санхүүгийн хүндрэлээс гаргах урьдчилсан төлөвлөгөө амжилтгүй хэрэгжсэн ХЗХ-г өөрчлөн байгуулагдахад нь мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

3.1.5 богино хугацаанд эх үүсвэр нэмэгдүүлэх хүсэлтэй ХЗХ-дод эргэн төлөгдөх нөхцөлтэй дэмжлэг үзүүлэх.

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 431 дүгээр тогтоолоор нэмсэн/

Дөрөв. Сангийн удирдлага, зохион байгуулалт

4.1. Сангийн удирдах зөвлөл нь Холбооны тэргүүлэгчдийн зөвлөл байна.

4.2. Тэргүүлэгчдийн зөвлөл дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

4.2.1. Сангийн үйл ажиллагааны жилийн төсвийг батлах;

4.2.2. Хорооноос батлагдсан журмын хүрээнд сангийн үйл ажиллагааны журам, заавруудыг батлах;

4.2.3. ХЗХ-доос жил бүр санд төвлөрүүлэх шимтгэлийн хэмжээг батлах;

4.2.4. сангийн бүтэц, орон тоог батлах;

4.2.5. сангийн гүйцэтгэх удирдлагыг томилох;

4.2.6. сангийн заавал байх нөөцийн доод хэмжээг хангаж ажиллах;

4.2.7. сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих;

4.2.8. сангийн дүгнэлтийг үндэслэн ХЗХ-нд санхүүгийн туслалцаа үзүүлэх талаарх саналаа Хороонд хүргүүлэх;

4.2.9. сангийн үйл ажиллагаа, хөрөнгийн зарцуулалтын талаарх тайланг гишүүн ХЗХ-дод танилцуулах.

4.3. Сангийн гүйцэтгэх удирдлага дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

4.3.1. сангийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;

4.3.2. сангийн ажилтанг томилох, чөлөөлөх, түүнтэй гэрээ байгуулах;

4.3.3. сангийн хөрөнгийг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулах;

4.3.4. санхүүгийн хүндрэлтэй ХЗХ-ны хүсэлтийн дагуу санхүүгийн туслалцаа үзүүлэх эсэх талаарх дүгнэлтийг Холбооны тэргүүлэгчдийн зөвлөлд хүргүүлэх;

4.3.5. жил бүр төвлөрүүлэх шимтгэлээ төлөхийг ХЗХ-доос шаардах;

4.3.6. сангийн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээг сар бүр гарган Холбооны тэргүүлэгчдийн зөвлөлд хүргүүлэх;

4.3.7. сангийн улирал, жилийн санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны жилийн тайланг улирал бүрийн дараа сарын 10-ны өдрийн дотор Хороонд ирүүлэх.

4.4. Сангийн гүйцэтгэх удирдлага нь дараах шаардлагыг хангасан байна:

4.4.1. банк, санхүү, эдийн засгийн мэргэжилтэй, мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан;

4.4.2. банк, санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн зээлийн өргүй;

4.4.3. ял шийтгэлгүй;

4.4.4. сүүлийн гурван жилийн хугацаанд санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаад дампуурсан хуулийн этгээдийн удирдлагад ажиллаж байгаагүй.

4.5. Сангийн гүйцэтгэх удирдлага нь Холбооны гүйцэтгэх удирдлагын албан тушаалыг давхар хашихыг хориглоно.

Тав. Сангаас хадгаламж, зээлийн хоршоодод санхүүгийн туслалцаа үзүүлэх

5.1. Холбоо нь ХЗХ-нд Хорооны зөвшөөрлийг үндэслэн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн туслалцааг үзүүлнэ.

5.2. Холбооноос олгох санхүүгийн туслалцааны дээд хэмжээ нь тухайн ХЗХ-ны санд төлсөн нийтшимтгэлийн хэмжээг гурав дахин нэмэгдүүлснээс илүүгүй байна.

5.3. Холбооноос ХЗХ-нд үзүүлэх нэг удаагийн санхүүгийн туслалцаа нь нэг жилээс хэтрэхгүй хугацаатай байна.

5.4. ХЗХ нь шимтгэлийг санд бүрэн төлсөн өдрөөс эхлэн санхүүгийн туслалцаа авах эрх нь үүснэ.

5.5. Холбоо нь санхүүгийн туслалцаа хүссэн ХЗХ-ны хүсэлтийг хүлээн авч дараах хяналтыг хэрэгжүүлнэ:

5.5.1. ХЗХ-ны эрсдэлийн түвшин, төлбөрийн чадварыг үнэлж, тодорхойлох;

5.5.2. ХЗХ-ны зээл, хадгаламжийн багц болон удирдлага, үйл ажиллагаагүнэлж, дүгнэлт өгөх.

5.6. Сан нь дараах нөхцөл бүрдсэнХЗХ-нд санхүүгийн туслалцаа үзүүлэх талаар дүгнэлт гарган Холбоонытэргүүлэгчдийн зөвлөлд хүргүүлнэ:

5.6.1. ХЗХ санхүүгийн хүндрэлд орсон;

5.6.2.ХЗХ-г санхүүгийн хүндрэлээс гаргах урьдчилсан төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломжтой;

5.6.3. шимтгэлээ бүрэн төлсөн.

5.7. Холбоо нь дараах тохиолдолд ХЗХ-нд санхүүгийн туслалцааүзүүлэхээс татгалзана:

5.7.1.санхүүгийн туслалцаа үзүүлсэн ч ХЗХ-ны санхүү, төлбөрийн чадвар нь сэргэх боломжгүй гэж дүгнэсэн;

5.7.2. шимтгэлээ бүрэн төлөөгүй.

5.8. Холбоо нь ХЗХ-нд санхүүгийн туслалцаа үзүүлэх зөвшөөрөл хүсэхдээ дараах баримт бичгийг бүрдүүлэн Хороонд ирүүлнэ:

5.8.1.ХЗХ-нд санхүүгийн туслалцаа үзүүлэх тухай Холбооны тэргүүлэгчдийн зөвлөлийн шийдвэр;

5.8.2. ХЗХ-нд санхүүгийн туслалцаа үзүүлэх тухай сангийн дүгнэлт, ХЗХ-г санхүүгийн хүндрэлээс гаргах урьдчилсан төлөвлөгөө;

5.8.3. ХЗХ-ны бүх гишүүдийн хурлын шийдвэр;

5.8.4.санхүүгийн туслалцаа хүссэн ХЗХ-ны үндэслэл бүхий хүсэлт.

5.9. Хороо нь Холбооны санал, холбогдох баримт бичгийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор Холбооноос ирүүлсэн санал болон хяналт шалгалтын дүгнэлтийг тус тус үндэслэн санхүүгийн туслалцаа үзүүлэх зөвшөөрөл олгох эсэх асуудлыг хянан шийдвэрлэнэ.

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 431 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан/

5.10. Хороо нь ХЗХ-нд санхүүгийн туслалцаа үзүүлэх зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд үндэслэл бүхий албан бичгийг Холбоонд хүргүүлнэ.

5.11. Сан нь ХЗХ-г санхүүгийн хүндрэлээс гаргах төлөвлөгөөний хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж, гүйцэтгэлийг хангуулж ажиллана.

Зургаа. Хадгаламж, зээлийн хоршоодын эрх, үүрэг

6.1. ХЗХ-д дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

6.1.1. санхүүгийн хүндрэлд орсон тохиолдолд Бүх гишүүдийн хурлын шийдвэрийг үндэслэн Холбооноос санхүүгийн туслалцаа хүсэх;

6.1.2. сангийн үйл ажиллагаа, хөрөнгийн зарцуулалтын тайлантай танилцах;

6.1.3. шимтгэл төлөх;

6.1.4. Холбооноос авсан санхүүгийн туслалцааг хугацаанд нь эргүүлэн төлөх.

Долоо. Сангийн үйл ажиллагаанд тавих хяналт, хориглох зүйл

7.1. Холбооны хяналтын зөвлөл нь сангийн үйл ажиллагаа болон санхүүгийн туслалцааны ХЗХ-дод шударга, хүртээмжтэй хүрч байгаа эсэхэд хяналт тавьж, дүгнэлт гаргах ба хяналтын тайлангаа жил бүрийн 2 дугаар сарын 10-ны өдрийн дотор Хороонд хүргүүлнэ.

7.2. Сангийн заавал байх нөөцийн доод хэмжээ хангагдаагүй бол санхүүгийн туслалцаа үзүүлэхийг хориглоно.

7.3. Сангийн хөрөнгийг журмын 3.1 дэх хэсэгт зааснаас өөр үйл ажиллагаанд зарцуулахыг хориглоно.

Найм. Хариуцлага

8.1. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 57.1.1 дэх заалтад заасны дагуу захиргааны хариуцлага хүлээлгэнэ.